



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2015 оны 9 сарын 10 өдөр

Дугаар А-127

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 337 дугаар тушаалаар батлагдсан “Монголбанкнаас хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-д дор дурдсан нэмэлтийг оруулсугай:

1.3 “Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх” гэсний дараа “олон нийтэд Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний хэрэгжилтийг тогтмол мэдээлэх, олон нийтийн эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх...,”

4.1 “Хэвлэл мэдээллийн байгууллагыг” гэсний өмнө “олон нийт, хэвлэл мэдээллийн...”

4.6 “ОНБМТ нь Монголбанкны бодлогын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх сурталчлах ажлын хүрээнд Монголбанкны бусад газар, хэлтэс, албадаас олон нийтэд нээлттэй мэдээллийг тухай бүр гаргуулан авах эрхтэй.”

4.7 “ОНБМТ-ийн захирал, мэргэжилтнүүд Монголбанкны Ерөнхийлөгчийн өгсөн чиглэлийн дагуу Монголбанкийг төлөөлж хэвлэлд ярилцлага, тодруулга өгөх эрхтэй.”

5.1 “Монголбанкны газар, хэлтэс, алба гэсний дараа “төвийн захирал болон ахлах эдийн засагч нар”

5.3 “...зөвшөөрөл авна.” гэсний дараа “Шаардлагатай тохиолдолд удирдлагын өгсөн чиглэлийн дагуу ОНБМТ-ийн захирал хэвлэлд төлбөртэй мэдээлэл гаргах зөвшөөрөл өгөх эрхтэй.”

2. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 337 дугаар тушаалаар батлагдсан “Монголбанкнаас хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ын 3, 4, 7 дахь заалтын дараах хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

3.1. “Жилийн турш зохион байгуулагдах Мөнгөний бодлогын зөвлөлийн шийдвэр гаргалттай холбоотой хэвлэлийн хурлын товыг оны эхэнд холбогдох газрууд болон ОНБМТ хамтран Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.”

3.2 “Мөнгөний бодлогын зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэвлэлийн хурлаар болон Монголбанкны цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.”

4.3. “Монголбанкны үйл ажиллагаа, удирдлагатай холбоотойгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан аливаа мэдээлэлд ОНБМТ-өөс дүн шинжилгээ хийж ташаа мэдээлэл, гүтгэлгийг залруулах ба шаардлагатай гэж үзвэл холбогдох газрын захиралд танилцуулна.”

7.5 “Эрдэм шинжилгээний ажлыг цахим хуудсанд байршуулахдаа хамрах хүрээ, чиглэлээс хамааран удирдлагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр нийтэлнэ.” гэж.

14 1222
Tushaal 2015.doc

3.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 337 дугаар тушаалаар батлагдсан “Монголбанкнаас хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ын Олон нийттэй харилцах хэлтэс (ОНХХ) гэснийг Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв (ОНБМТ) гэж, 3.4 дэх хэсгийн “...Монголбанкны Захирлуудын зөвлөлөөс...” гэснийг “...Мөнгөний бодлогын зөвлөлөөс...” гэж, 4.5 дахь хэсгийн “...урамшуулна.” гэснийг “...урамшуулах эрхтэй.” гэж, 3.4, 3.5, 3.6, 3.7, 3.9 дэх хэсгийн дугаарлалтыг 3.3, 3.4, 3.5, 3.6, 3.7 гэж, 6.1 дэх хэсгийн “Шаардлагатай гэж үзвэл” гэснийг “ОНБМТ-өөс шаардлагатай тохиолдолд олон нийт” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 337 дугаар тушаалаар батлагдсан “Монголбанкнаас хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ын 3.3, 3.8 дахь хэсэг болон 5.2 дахь хэсгийн “Сонин, сэтгүүл, телевиз, радиогийн байгууллагыг сонгохдоо” гэсний дараах “Монголбангтай хамтран ажиллах гэрээ байгуулсан эсэх” гэснийг тус тус хассугай.

5.Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв (Ю.Гэрэлтуяа)-д үүрэг болгосугай.

6.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

МОНГОЛБАНКНААС ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ,

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЖУРАМ

- НЭГ. Нийтлэг үндэслэл
- ХОЁР. Монголбанкны мэдээллийн болон түүнийг хэрэглэгчдийн ангилал
- ГУРАВ. Монголбанкны хэвлэлийн хурлын тухай
- ДӨРӨВ. ОНБМТ-ийн эрх, үүрэг
- ТАВ. Монголбанкнаас мэдээ, мэдээллийг түгээх
- ЗУРГАА. Монголбанкнаас мэдээ, мэдээлэл хүсэх
- ДОЛОО. Судалгааны ажлыг Монголбанкны цахим хуудсанд байршуулах
- НАЙМ. Бусад

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Монголбанкны үндсэн зорилт, түүнтэй холбогдсон хууль журмын биелэлтийг Монголбанкны цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан өргөн олон нийтэд мэдээлэх, сурталчлах, сэтгүүлчидтэй хамтран ажиллах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийттэй Монголбанкнаас харилцах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго нь оршино.

1.2 Энэхүү журам нь Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Монголбанкны хөдөлмөрийн дотоод журам, Монголбанкны нууцын тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн үзэл санаанд нийцсэн байна.

1.3 Монголбанк нь Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв (ОНБМТ)-тэй байна. ОНБМТ-ийн үндсэн зорилт нь бага, тогтвортой инфляцийн тухай ойлголтыг түгээх, Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх; **олон нийтэд Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний хэрэгжилтийг тогтмол мэдээлэх, олон нийтийн эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх**, нээлттэй, ил тод байж Төв банкны бие даасан, хараат бус үйл ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

[МБЕ-ийн 2015.9.10-ны А-127 дугаар тушаалаар нэмсэн.](#)

1.4 Төрийн нууц болон байгууллагын нууцад хамаарахаас бусад Монголбанкны үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг нийтэд нээлттэй, шуурхай, бодитой, үнэн зөв хүргэх ажлыг ОНБМТ эрхлэн гүйцэтгэнэ.

1.5 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах Монголбанкны үндсэн арга хэлбэр нь Хэвлэлийн хурал, Монголбанкны цахим хуудас болно.

ХОЁР. Монголбанкны мэдээллийн болон түүнийг хэрэглэгчдийн ангилал

- 2.1 Монголбанкнаас түгээж байгаа мэдээ, мэдээллийг бодлогын болон бусад мэдээлэл гэж тус тус ангилна.
- 2.2 Монголбанкны бодлогын мэдээлэлд Монголбанкны Хэвлэлийн мэдээлэл, Улирлын мөнгөний тойм, УИХ-ын ЭЗБХ-нд “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-ийн биелэлтийн талаар Монголбанкны Ерөнхийлөгчийн тавих илтгэл, Монголбанкны жилийн тайлан, Монголбанкны статистикийн сарын бюллетень, Монголбанкны албан ёсны мэдэгдэл, хэвлэмэл мэдээлэл зэргийг хамруулж ойлгоно.
- 2.3 Монголбанкны бусад мэдээлэлд Монголбанкны төлөвлөгөөт ажлын хүрээнд зохиогдож буй арга хэмжээний талаарх нийтлэл, мэдээлэл, орчуулга, ажлын зар, тендерийн урилга, ханшийн мэдээ, мэндчилгээ, Ерөнхийлөгч нарын болон газар, хэлтэс, албадын захирлуудын ярилцлага, Монголбанкны үйл ажиллагааны талаар төвийн хэвлэл мэдээлэлд гарсан ташаа мэдээллийг залруулах залруулга, тайлбар зэрэг багтана.
- 2.4 Монголбанкны мэдээлэл хэрэглэгчдийг Олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд; УИХ, Засгийн газар; Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаанд оролцогчид; Төв банкны үйл ажиллагааг ажиглагчид гэсэн үндсэн 4 бүлэгт хуваана.
- 2.5 ОНБМТ-өөс хэрэглэгчийн бүлэг тус бүрт тохирсон зорилтыг тодорхойлж харилцах арга хэлбэрээ сонгоно.

ГУРАВ. Монголбанкны хэвлэлийн хурлын тухай

- 3.1 Жилийн турш зохион байгуулагдах мөнгөний бодлогын зөвлөлийн шийдвэр гаргалттай холбоотой хэвлэлийн хурлын товыг оны эхэнд холбогдох газрууд болон ОНБМТ хамтран Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдэгдэнэ.
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-127 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)
- 3.2 Мөнгөний бодлогын зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэвлэлийн хурлаар болон Монголбанкны цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-127 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)
- 3.3 ~~Тус хурлаас гарсан бодлогын шийдвэрээр дараагийн одор буюу Пүрэв гаригт Монголбанкнаас Хэвлэлийн хурлыг зарлан хуралдуулна.~~
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-127 дугаар тушаалаар хассан.](#)
- 3.3 Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтаар хийх Хэвлэлийн хуралд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нарын аль нэг нь оролцон мэдээлэл хийнэ. Ингэхдээ зөвхөн **Мөнгөний бодлогын зөвлөлөөс** гарсан албан ёсны шийдвэрийг танилцуулах бөгөөд хувийн байр сууриа илэрхийлэхээс зайлсхийнэ.
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-127 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

3.4 Цаг үеийн сэдвээр хийх Хэвлэлийн хуралд Монголбанкны удирдлага, газрын захирлууд оролцож сэтгүүлчдэд мэдээлэл хийнэ. Үүнд:

3.4.1 ХҮИ, түүний задаргаа, суурь инфляци; мөнгөний нийлүүлэлт; эдийн засгийн бодит секторын төлөв байдал;

3.4.2 Ханшийн төлөв байдал, гадаад валютын албан нөөц;

3.4.3 Банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, олгосон зээл, чанаргүй зээл, ашигт ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд гэх мэт.

3.5 Хэвлэлийн хурлын мэдээ материалыг Монголбанкны газар, хэлтсээс заавал урьдчилан бэлтгэж сэтгүүлчдэд Хэвлэлийн хурал эхлэхээс 10 минутын өмнө тараана.

3.6 Шаардлагатай тохиолдолд ОНБМТ ээлжит бус Хэвлэлийн хурлыг зохион байгуулж болно.

3.7 Мөнгөний бодлогын мэдэгдлийг заасан хугацаанаас наана олон нийтэд аливаа хэлбэрээр ил болгохыг хориглоно.

3.8 ~~Хэвлэлийн хурал хуралдахаас өмнөх 8 хоногийн хугацаанд Монголбанк хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдэд аливаа асуудлаар ярилцлага, тайлбар өгөхгүй.~~
[МБЕ-ийн 2015.09.10-ны А-127 дугаар тушаалаар хассан.](#)

ДӨРӨВ. ОНБМТ-ийн эрх, үүрэг

4.1 **Олон нийт**, хэвлэл мэдээллийн байгууллагыг Монголбанкны үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах; газар, хэлтэс, албадаас ирүүлсэн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, төлбөртэй сурталчилгааг зуучлах ажлыг ОНБМТ зохион байгуулна.

[МБЕ-ийн 2015.9.10-ны А-127 дугаар тушаалаар нэмсэн.](#)

4.2 ОНБМТ нь Монголбанкны цахим хуудсанд шинэ мэдээлэл гаргах ажлыг газар, хэлтэс, албадтай хамтран гүйцэтгэнэ. Тус цахим хуудасны ажиллах журмыг “Монголбанкны цахим хуудас эрхлэх журам”-аар зохицуулна.

4.3 Монголбанкны үйл ажиллагаа, удирдлагатай холбоотойгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан аливаа мэдээлэлд ОНБМТ-өөс дүн шинжилгээ хийж ташаа мэдээлэл гүтгэлгийг залруулах ба шаардлагатай гэж үзвэл холбогдох газрын захиралд танилцуулна.

[МБЕ-ийн 2015.09.10-ны А-127 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

4.4 ОНБМТ-ийн захирал Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хуралд ажиглагчаар суух эрхтэй.

4.5 Монголбанкны бодлогыг олон нийтэд үнэн зөв, шуурхай хүргэх ажилд идэвхи зүтгэлтэй ажилласан хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг ОНБМТ-өөс шалгаруулж **урамшуулах эрхтэй.**

[МБЕ-ийн 2015.09.10-ны А-127 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

4.6 ОНБМТ нь Монголбанкны бодлогын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх сурталчилах ажлын хүрээнд Монголбанкны бусад газар, хэлтэс, албадаас олон нийтэд нээлттэй мэдээллийг тухай бүр гаргуулан авах эрхтэй.

[МБЕ-ийн 2015.9.10-ны А-127 дугаар тушаалаар нэмсэн.](#)

4.7 ОНБМТ-ийн захирал, мэргэжилтнүүд Монголбанкны Ерөнхийлөгчийн өгсөн чиглэлийн дагуу Монголбанкийг төлөөлж хэвлэлд ярилцлага, тодруулга өгөх эрхтэй.

[МБЕ-ийн 2015.9.10-ны А-127 дугаар тушаалаар нэмсэн.](#)

ТАВ. Монголбанкнаас мэдээ, мэдээллийг түгээх

5.1 Монголбанкны газар, хэлтэс, алба, **төвийн захирал болон ахлах эдийн засагч нар** Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлж ярилцлага өгөх, нийтлэл нийтлүүлэх эрхтэй.

[МБЕ-ийн 2015.9.10-ны А-127 дугаар тушаалаар нэмсэн.](#)

5.2 Сонин, сэтгүүл, телевиз, радиогийн байгууллагыг сонгохдоо ~~Монголбанстай хамтран ажиллах гэрээ байгуулан эеж~~, захиалагч, үзэгч, сонсогчдын тоо, хөдөө орон нутагт хүрэх хүртээмжийн байдал, түгээлтийн хэмжээ, нэг өдөрт хэвлэгдэн гардаг тоо ширхэг, олон нийтийн дундах нэр хүнд, мэдээллийн үнэн зөв байдлыг хэр анхаардаг зэргийг харгалзан ОНБМТ сонгоно.

[МБЕ-ийн 2015.09.10-ны А-127 дугаар тушаалаар хассан.](#)

5.3 Газар, хэлтэс, албад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байршуулах төлбөртэй зар сурталчилгаа, нийтлэл, орчуулга, ярилцлагыг хариуцсан Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч нарт танилцуулж “Хэвлэлд төлбөртэй мэдээлэл өгөх зөвшөөрөл”-ийн маягтад гарын үсэг зуруулан зөвшөөрөл авна. **Шаардлагатай тохиолдолд удирдлагын өгсөн чиглэлийн дагуу ОНБМТ-ийн захирал хэвлэлд төлбөртэй мэдээлэл гаргах зөвшөөрөл өгөх эрхтэй.** Зөвхөн зөвшөөрөгдсөн материалыг ОНБМТ-өөс хэвлэлд нийтлүүлнэ. Мэдээллийн зөвшөөрөл олгох маягтыг энэхүү журмын Хавсралт 1-ээр батална.

[МБЕ-ийн 2015.9.10-ны А-127 дугаар тушаалаар нэмсэн.](#)

5.4 Газар, хэлтэс, албад цахим хуудсанд байршуулах зар сурталчилгаа, нийтлэл, орчуулгыг газрын захирал нарт танилцуулж “Цахим хуудсанд мэдээлэл байршуулах зөвшөөрөл”-ийн маягтад гарын үсэг зуруулан зөвшөөрөл авна. Зөвхөн зөвшөөрөгдсөн материалыг ОНБМТ-өөс цахим хуудсанд байршуулна. Мэдээллийн зөвшөөрөл олгох маягтыг энэхүү журмын Хавсралт 2-оор батална.

ЗУРГАА. Монголбанкнаас мэдээ, мэдээлэл хүсэх

6.1 **ОНБМТ-өөс шаардлагатай тохиолдолд олон нийт**, хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчдээс ирүүлсэн мэдээ, мэдээлэл авах, уулзаж ярилцах хүсэлтийг амаар болон бичгээр холбогдох газар, хэлтэс, албадын дарга нарт хүргүүлнэ. Хариуг шууд эсхүл Хэвлэлийн хурлаар дамжуулан өгөхийг газар, хэлтэс, албадын захирлууд шийдвэрлэх бөгөөд шийдвэрийг ОНБМТ-өөс ажлын 2 өдрийн дотор хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд эргэн мэдэгдэнэ.

[МБЕ-ийн 2015.09.10-ны А-127 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

6.2 Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, Монголбанкны нэр хүндэд ноцтой халдсан онцгой тохиолдолд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлсэн ярилцлагыг телевиз, радио, сонины сурвалжлагч нарт Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, газрын захирлууд өгнө. Ярилцлага авах телевиз, радио, сонинг ОНБМТ сонгож, тавигдах асуултыг урьдчилан авна.

6.3 Шаардлагатай гэж үзвэл Хэвлэлийн хурлын мөрөөр нэмэлт тайлбар мэдээллийг ОНБМТ-өөс нийтлэл, ярилцлага хэлбэрээр хүргүүлж болно.

6.4 Гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагаас санал ирсэн, эсхүл гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслээр Монголбанкны үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл, танилцуулга, ярилцлага нийтлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгчид танилцуулж, өгсөн чиг үүргийн дагуу холбогдох газар, хэлтэс, албатай хамтран мэдээ, мэдээлэл боловсруулах ажлыг ОНБМТ зохион байгуулна.

ДОЛОО. Судалгааны ажлыг Монголбанкны цахим хуудсанд байршуулах

7.1 Цахим хуудсанд Монголбанкны үндсэн зорилго, удирдлага, мөнгөний бодлогын шилжих механизм, мөнгөний бодлогын томъёолол, хэрэгсэл, үйл ажиллагааны талаархи дэлгэрэнгүй мэдээллийг заавал тусгасан байна.

7.2 Монголбанк статистик, эконометрикийн аргыг ашиглан эдийн засаг, банк санхүүгийн салбарын судалгааны ажлыг тогтмол гүйцэтгэн олон нийтэд хүргэнэ.

7.3 Судалгааны ажлыг бодлогын шийдвэрт ашиглагдаж буй танилцуулга болон эрдэм шинжилгээний ажил гэсэн үндсэн хоёр бүлэгт хуваана.

7.4 Бодлогын шийдвэрт ашиглагдаж буй танилцуулгыг Захирлуудын зөвлөлд танилцуулан саналыг нь авсны үндсэн дээр цахим хуудсанд байршуулна.

7.5 Эрдэм шинжилгээний ажлыг цахим хуудсанд байршуулахдаа хамрах хүрээ, чиглэлээс хамааран удирдлагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр нийтлэнэ.

[МБЕ-ийн 2015.09.10-ны А-127 дугаар тушаалаар өөрчилсөн.](#)

8.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Монголбанк, түүний удирдлагын нэр хүндэд ор үндэслэлгүйгээр удаа дараа ноцтой халдсан тохиолдолд асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

8.2 Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Монголбанкны дотоод журамд зааснаар зохицуулна.

8.3 Монголбанкны албан тушаалтан энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛБАНК

ХЭВЛЭЛД ТӨЛБӨРТЭЙ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ЗӨВШӨӨРӨЛ

МОНГОЛБАНК

Монгол Улс, Улаанбаатар хот - 11, Бага тойруу - 9,

Утас: 312939, Факс: 311471

Огноо:	
Зөвшөөрөл өгсөн: <ul style="list-style-type: none">• Ерөнхийлөгч• Тэргүүн Дэд Ерөнхийлөгч• Дэд Ерөнхийлөгч	
Боловсруулсан:	
Мэдээллийн гарчиг:	
Мэдээлэл түгээх суваг /ТВ, радио, сонин/:	
Мэдээлэл түгээх ТВ, радио, сонины нэр:	
Хэвлэлд нийтлэх огноо:	
Давталт:	
ОНБМТ-д мэдээллийг хүлээлгэн өгсөн:	
Гарах төсөв, төгрөгөөр:	

ЦАХИМ ХУУДСАНД МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

МОНГОЛБАНК

Монгол Улс, Улаанбаатар хот - 11, Бага тойруу - 9,

Утас: 312939, Факс: 311471

Огноо:	
Зөвшөөрөл өгсөн: <ul style="list-style-type: none">• Газрын захирал• Хэлтсийн захирал• Албаны захирал	
Боловсруулсан:	
Мэдээллийн гарчиг:	
ОНБМТ-д мэдээллийг хүлээлгэн өгсөн:	